

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-133-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p>Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> /14 хуудас NZ Part 133-ийн 2007 оны 10 сарын 25-ны А.3-д үндэслэсэн/</p>	<p align="center">НИСДЭГ ТЭРЭГНИЙ ДҮҮЖИН ТЭЭВЭРЛЭЛТ <i>(Хүчинтэй мөрдөгдөж байгаа)</i> /8 хуудас (үндсэн дүрэм-17 хуудастай байсан)/ 1997 оны orijinal</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>133.1. Хамрах хүрээ (a) ИНД-133 нь нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээдийн ИНД-91-д заасан нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрмийн үл хамаарах шаардлага болон нэмэлт шаардлагыг тогтооно. (b) ИНД-133 нь спортын, эсхүл сургалтын зорилгоор нисдэг тэргэний доор хүн өргөх, эсхүл нисдэг тэргээр зорилгоор хүн чирэх үйл ажиллагаанд хамаарахгүй.</p>	<p>133.1. Зорилго (a) Нисдэг тэргээр хүн ба ачааг дүүжин хэлбэрээр өргөх, буулгах, зөөвөрлөх ажиллагааг ИНД-91-ийн заалтуудад нийцүүлэн зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино. (b) Энэ дүрэм нь нисдэг тэргээр спорт, зугаа цэнгээний зорилгоор дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх үйл ажиллагаанд хамаарахгүй.</p>	<p>-Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>133.3. Нэр томъёо болон товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>133.3. Тодорхойлолт</p>	<p>- Нэр томъёоны тайлбар,тодорхойлолтууд ИНД-1-д орсон.</p>
<p>133.5. Нисгэгчийн үнэмлэхний шаардлага. (a) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэргэний дарга нь дараах үнэмлэх зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй: (1) хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (нисдэг тэрэг): эсхүл (2) хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх (нисдэг тэрэг) хэрэв нисгэгч нь ИНД-61.153-т шаардсан татлагаар хүн зөөх сургалтад амжилттай хамрагдсан болохыг Багш нисгэгч (нисдэг тэрэг) нислэгийн дэвтэрт нь баталгаажуулсан бол. (b) Энэ зүйлийн (a)(2)-ыг үл харгалзан, өргөгч-техөөрөмжөөр өргөх эсхүл буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх үйл ажиллагааг нисдэг тэргээр гүйцэтгэж байгаа нисдэг тэргэний дарга нь хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх (нисдэг тэрэг) эзэмшдэг байх үүрэгтэй. (c) Энэ зүйлийн (a) (b)-г үл харгалзан, сургалтад хамрагдаж байгаа нисгэгч хэрэв, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхийн өмнө Багш нисгэгчийн зэрэглэл (нисдэг тэрэг) эзэмшигч зөвшөөрсөн бол хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх</p>	<p>133.5. Нисгэгчийн үнэмлэхэнд тавигдах шаардлага. (a) Нисдэг тэргээр дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь: 1/ коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй байна, эсхүл 2/ багш нисгэгч нислэгийн дэвтэрт нь ИНД-61-д заасан хувийн нисгэгчийн үнэмлэхний шаардлага хангасан тухай тэмдэглэл хийсэн тохиолдолд хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй (нисдэг тэргэний) байна. (b) Хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглан хүн өргөх, буулгах болон олс оосор ашиглан хүн буулгах ажиллагаа гүйцэтгэх, эсхүл дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх агаарын хөлгийн дарга нь энэ зүйлийн (a) 2/-т заасныг үл харгалзан коммерийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байна. (в) Коммерийн, эсхүл хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр бус үнэмлэхтэй нисгэгч, хэрэв багш нисгэгч зөвшөөрвөл, энэ зүйлийн (a), (б)-д заасныг үл харгалзан дүүжин тээвэрлэлтэд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр сургалт дадлага авч болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(нисдэг тэрэг), эсхүл хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэхгүйгээр (нисдэг тэрэг) нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх сургалтын үйл ажиллагаанд нисдэг тэрэгний даргын үүрэг гүйцэтгэж болно.</p>		
	<p>133.7. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх (а) ИНЕГ-ын дарга нь аливаа этгээдийг энэ дүрмийн шаардлагаас ИНД-11-ийн дагуу чөлөөлж болно.</p>	<p>-Amend.2-оор хасагдсан</p>
<p>В Бүлэг - Үйл ажиллагааны дүрэм болон холбогдох шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ, ШААРДЛАГА</p>	
<p>133.51. Минимум аюулгүй өндөр (а) ИНД-91.311-ийг үл харгалзан хэрэв тухайн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай бол нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга гадаргуу дээрх хүн эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулахгүй байх боломжит арга хэмжээг авсан тохиолдолд, ойртолт, хөөрөлт үйлдэх болон ачааг байрлуулах маневрыг багтаасан үйл ажиллагааг гадаргуугаас дээш 150 м-ээс (500 ft) бага нам өндөрт, хүн, усан онгоц, тээврийн хэрэгсэл болон байгууламжаас 150 м-ээс дотогш зайд гүйцэтгэж болно. (б) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь газар дээрх хүн, эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулахгүйгээр онцгой нөхцөлийн үед салгах боломжтой (jettisonable) дүүжин ачааг хаяж буулт үйлдэх боломжтой өндөр болон замаар тухайн нислэгийг гүйцэтгэж байгааг бататгах боломжит арга хэмжээг авах үүрэгтэй.</p>	<p>133.51. Нислэгийн хамгийн бага аюулгүй өндөр (а) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэж буй агаарын хөлгийн дарга нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд газар дээрх хүн болон эд зүйлсэд аюул учруулахгүй гэж үзвэл ИНД-91-ийн холбогдох заалтыг үл харгалзан, газрын гадаргууд 150 м (500 фут)-ээс доош өндөрт, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүмүүст 150 м (500 фут)-ээс дотогш зайд ойртох, хөөрөх, ачаа байрлуулах жолоодлогыг гүйцэтгэж болно. (б) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэж буй агаарын хөлгийн дарга онцгой тохиолдолд гадна ачааг хаях, эсхүл буулт үйлдэхэд хүн болон эд зүйлсэд аюул учруулахгүй байхаар тооцон тухайн нислэгийн өндөр, чиглэлийг тогтооно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.53. Хүн зөөх (а) Нисдэг тэрэгний дарга нь нисдэг тэргээр дүүжин ачаа чирэх үйл ажиллагаа гүйцэтгэхдээ тухайн дүүжин ачаа чирэх үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үүрэг гүйцэтгэдэггүй этгээдийг тухайн нисдэг тэргэнд тээвэрлэхгүй. (б) Нисдэг тэргээр татлагаар хүн зөөх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь дараахаас бусад тохиолдолд, нисдэг тэргээр татлагаар хүн зөөх үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үүрэг гүйцэтгэдэггүй этгээдийг тухайн нисдэг тэргэнд тээвэрлэхгүй: (1) тухайн үйл ажиллагаа нь татлагаар хүн зөөх үйл ажиллагаа биш бол; (2) тухайн этгээд нь татлагаар хүн зөөхтэй холбоотой газарт ажил үүрэг гүйцэтгэх шаардлагатай бол; (3) тухайн үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй бол.</p>	<p>133.53. Хүн тээвэрлэх (а) Агаарын хөлгийн дарга нь дүүжин тээвэрлэлтээр хүн зөөвөрлөх тохиолдолд тухайн ажиллагаанд шууд оролцохгүй этгээдийг нисдэг тэргэнд тээвэрлэхгүй. (б) Агаарын хөлгийн дарга нь тухайн ажиллагааны хувьд багшлах эрхтэй бол, энэ зүйлийн (а)-д заасныг үл харгалзан дадлага хийж буй нисэх багийн гишүүнийг нисдэг тэргэнд тээвэрлэж болно.</p>	

<p>(c) Нисдэг тэрэгний дарга нь өргөгч-төхөөрөмжөөр өргөх эсхүл буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх үйл ажиллагааг гүйцэтгэхдээ, өргөгч-төхөөрөмжөөр өргөх эсхүл буулгах олсоор буулгах эсхүл татлагаар хүн зөөхтухайн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үүрэг гүйцэтгэдэггүй этгээдийг нисдэг тэргэнд тээвэрлэхгүй.</p> <p>(d) Энэ зүйлийн (a), (b) болон (c)-г үл харгалзан дараах тохиолдолд нисдэг тэрэгний дарга нь нислэгийн бүхээгт дадлага хийж байгаа тухайн үйл ажиллагаанд зайлшгүй үүрэг гүйцэтгэдэггүй багийн гишүүнийг нисдэг тэргэнд тээвэрлэж болно:</p> <p>(1) тухайн нисдэг тэрэгний дарга нь гүйцэтгэх үйл ажиллагааны төрөлд зааварчилгаа өгөхөөр мэргэшсэн байх;</p> <p>(2) тухайн үйл ажиллагааны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх.</p>		<p>-Орхигдуулсан шаардлагыг нэмж тусгасан</p>
<p>133.55. Гуравдагч этгээдийн эрсдэл</p> <p>(a) Нисдэг тэрэгний дарга нь нисдэг тэрэгний доор татлагаар дүүжилсэн ачааг дараах нөхцөлд тээвэрлэхгүй:</p> <p>(1) тухайн этгээдээс зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд аливаа хүн, эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулах хэлбэрээр; эсхүл</p> <p>(2) олон хүн цугларсан задгай талбай дээгүүр.</p> <p>(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд оролцон агаарт тогтох нислэг үйлдэж байгаа нисдэг тэрэгний дарга нь, тухайн үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлагатай бөгөөд дараах зааварчилгаа авснаас бусад этгээд нисдэг тэрэг агаарт тогтох тухайн нислэгийн бүсэд байхгүй болохыг бататгана:</p> <p>(1) дүүжин ачаа тээвэрлэх хэвийн нөхцөлийн журам;</p> <p>(2) онцгой нөхцөлийн үед бүх ажилтны мөрдөх журам;</p> <p>(3) тухайн ачааны онцлог болон үйлчилгээний тусгай шаардлага;</p> <p>(4) тухайн нисдэг тэрэгний өргөх чадал;</p> <p>(5) тухайн үйл ажиллагаатай холбоотой гараар өгөх, эсхүл радио дохио.</p> <p>(c) Газар дээр байгаа гэмтэж бэртсэн хүнд тусламж үзүүлж байгаа тохиолдолд энэ зүйлийн (b) заалтыг мөрдөхийг шаардахгүй.</p>	<p>133.55. Гуравдагч этгээдийн эрсдэл</p> <p>(a) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд дүүжин тээвэрлэлт гүйцэтгэж болохгүй:</p> <p>1/ хүн болон эд зүйлд аюул учруулахаар бол;</p> <p>2/ хүн олноор цугларсан газрын дээгүүр.</p> <p>(б) Энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд, дүүжин тээвэрлэлтийн үед дүүжин нислэг гүйцэтгэх агаарын хөлгийн дарга тухайн талбайд хүн ба эд зүйл байхгүй гэдгийг магадлах ба тухайн ажиллагаанд оролцох хүмүүст нислэгийн өмнө дараах зааврыг өгсөн байна:</p> <p>1/ дүүжин тээвэрлэлтийн хэвийн ажиллагаа;</p> <p>2/ онцгой тохиолдлын үед дагаж мөрдөх ажиллагааны журам;</p> <p>3/ ачааны төрөл, хэлбэр, тэдгээртэй ажиллах тусгай шаардлагууд;</p> <p>4/ нисдэг тэрэгний өргөх боломж, чадал;</p> <p>5/ тухайн ажиллагаанд хэрэглэх гар болон радио дохио.</p> <p>(в) Газарт гэмтэл авсан хүнд тусламж хүргэж буй тохиолдолд энэ зүйлийн (б)-г дагаж мөрдөхийг шаардахгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“дүүжин тээвэрлэлт”-ийг “татлагаар ачаа тээвэрлэх” гэж өөрчилсөн</p>
<p>133.57. Жингийн хязгаарлалт</p> <p>Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний хөлгийн дарга, тухайн тээвэрлэх ачааны</p>	<p>133.57. Жингийн хязгаарлалт</p> <p>(a) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга, зөөвөрлөх ачааны жин нь энэ дүрмийн 133.255-ын 1/-д</p>	<p>-Орчуулга,</p>

<p>жин нь 133.255(1)-д шаардсан ачааны өргөх дэгээ, эсхүл хэрэгслийн жингийн хязгаарлалтаас хэтрэхгүй байхыг бататгана.</p>	<p>заагдсан өргөх дэгээ буюу хэрэгслийн хувьд тэдгээрийн даацын хязгаарлалтаас илүүгүй гэдгийг бататгана</p>	<p>найруулга зассан</p>
<p>133.59. Ил харааны нислэгийн дүрэм (VFR) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга, тухайн үйл ажиллагааг VFR-ийн дагуу гүйцэтгэдэг байхыг бататгана.</p>	<p>133.59. Ил харааны нислэгийн дүрэм (а) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь нислэгийг ил харааны нислэгийн дүрмээр гүйцэтгэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.61. Шөнийн үйл ажиллагаа Нисдэг тэрэгний дарга нисдэг тэрэгний гэрэл, газрын гэрэл, эсхүл байгалийн гэрлээр хангалттай гэрэлтүүлсэн гадны баримжаат цэгээр Хөлгийн дарга, тухайн нисдэг тэрэгний нислэгийн байрлал, өндөр болон байршлыг хадгалж чадахгүй тохиолдолд шөнийн цагаар нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.</p>	<p>133.61. Шөнийн нислэгийг хязгаарлах (а) Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэгний гэрэлтүүлэг, газрын гэрэлтүүлэг, эсхүл байгалийн гэрэлд харагдах гадны биетийн тусламжтайгаар нисдэг тэрэгний байршил, байрлал, өндрийг тодорхойлж чадахааргүй бол шөнийн цагт дүүжин тээвэрлэлтийн нислэг үйлдэж болохгүй.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.63. Ачаа тээвэрлэх Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь 133.255(1)-д шаардсан өргөх дэгээ, эсхүл хэрэгслийг ашиглан тухайн дүүжин ачааг тээвэрлэдэг болохыг бататгана.</p>	<p>133.63. Ачаа зөөвөрлөх (а) Агаарын хөлгийн дарга нь дүүжин тээвэрлэлтийг энэ дүрмийн 133.255-ын 1/-д заагдсан өргөх дэгээ, хэрэгслээр тоноглогдсон нисдэг тэргээр гүйцэтгэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.65. Аюултай бараа (а) Нисдэг тэрэгний дарга, дараах тохиолдолд ИНД-92-ыг мөрдөхгүйгээр Ангилал 1-ийн аюултай барааг нисдэг тэрэгний доор бэхэлсэн татлагаар тээвэрлэхээр хүлээн авч болно, хэрэв: (1) тухайн аюултай барааг ИНД-92-т заасан зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч тээвэрлэхийг зөвшөөрсөн бол; (2) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол. (3) тухайн аюултай бараа нь: (i) агаараар тээвэрлэхэд тохиромжтой нөхцөлд байгаа бол; (ii) аюулгүй тээвэрлэлтэд зориулан байрлуулсан ба бэхэлсэн бол. (4) тухайн үйл ажиллагааг хот,сум эсхүл суурингийн шигүү суурьшлын бүсээс зайтай гүйцэтгэх бол. (б) Нисдэг тэрэгний дарга, дараах тохиолдолд ИНД-92-ыг мөрдөхгүйгээр Ангилал 2-оос Ангилал 9-ийн аюултай барааг нисдэг тэрэгний доор бэхэлсэн татлагаар тээвэрлэхээр хүлээн авч болно, хэрэв: (1) тухайн аюултай барааг тээвэрлэхийг Техник зааварчилгаагаар хориглоогүй бол; (2) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй байдлын болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол; (3) тухайн аюултай барааны бүрийг таньж тогтоосон бол;</p>	<p>133.65. Аюултай ачаа (а) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд ИНД-92-ыг үл харгалзан, нисдэг тэргээр 1-р ангиллын аюултай ачааг дүүжин хэлбэрээр зөөвөрлөж болно: 1/ ИНЕГ-ын эрх бүхий байцаагч зөвшөөрсөн бол; 2/ тухайн ачааг зөөвөрлөхөд шаардагдах аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журамтай бол; 3/ тухайн ачаа нь: 3.1 агаараар зөөвөрлөх зохих нөхцлөөр хангагдсан бол, 3.2 зөөвөрлөхөд аюулгүй байхаар баглагдаж, хамгаалагдсан бол. 4/ тухайн ажиллагааг хот суурин болон хүн ам шигүү суурьшсан газар нутгаас алслагдсан зайд гүйцэтгэх бол. (б) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд ИНД-92-ыг үл харгалзан, нисдэг тэргээр 2-9 дүгээр ангиллын аюултай ачааг дүүжин хэлбэрээр зөөвөрлөж болно: 1/ тухайн аюултай ачааны техник ажиллагааны зааварт зөөвөрлөхийг хориглоогүй бол; 2/ тухайн ачааг зөөвөрлөхөд шаардагдах аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журамтай бол;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“Ачаа” гэснийг “бараа” гэж өөрчилсөн</p>

<p>(4) тухайн аюултай барааны аюултай шинж чанарыг нисдэг тэрэгний даргад мэдэгдсэн бол;</p> <p>(5) тухайн аюултай бараа нь:</p> <p>(i) агаараар тээвэрлэх тохиромжтой нөхцөлд байгаа бол;</p> <p>(ii) хэрэв хоорондоо урвалд орж аюултай байдал үүсгэх болох бол, тусгаарласан байх байрлуулсан, бэхэлсэн байх;</p> <p>(iii) хэрэв шаардлагатай бол нислэгийн үед асгарах, эсхүл гэмтэхээс сэргийлж савласан байх.</p>	<p>3/ аюултай ачаа бүр таних тэмдэгтэй бол;</p> <p>4/ агаарын хөлгийн дарга нь ачааны аюултай шинж чанарын тухай мэдээллээр хангагдсан бол;</p> <p>5/ аюултай ачаа нь:</p> <p>5.1 агаараар зөөвөрлөх зохих нөхцөлөөр хангагдсан бол;</p> <p>5.2 өөр хоорондоо урвалд орох ачааг ялгаж тусгаарласан бол;</p> <p>5.3 нислэгийн явцад гэмтэх, асгарахаас сэргийлсэн баглаа, боодолтой бол.</p>	
<p>133.67. Нислэгийн үзүүлэлт</p> <p>(a) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь нисдэг тэрэг тухайн ачаалах талбайг орхихоос өмнө ачааг зөв тохируулсан байрлуулсан болохыг бататгана.</p> <p>(b) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь тухайн нисдэг тэрэг болон ачааны бүрэн хяналтыг хадгалж байх нөхцөлд болон хэлбэрээр нислэг үйлдэнэ.</p>	<p>133.67. Үйл ажиллагааны ерөнхий шаардлага</p> <p>(a) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэг ачаалалтын талбайгаас хөөрөхөөс өмнө ачааг зөв байрлуулсан, бэхэлсэн гэдгийг бататгана.</p> <p>(б) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нисдэг тэргийг болон дүүжин ачааг удирдаж, хянахад тохиромжтой нөхцөлд нислэгийг үйлдэнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.69. Шигүү суурьшлын бүс дээгүүрх үйл ажиллагаа Хот, сүм эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр, эсхүл түүний дэргэд нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх ба үйл ажиллагаанд оролцох бүх хүнд дараах мэдээллийг багтаасан зааварчилгаа өгөх:</p> <p>(i) нислэгийн зам болон түвшнийг харуулсан нислэгийн зураг;</p> <p>(ii) нислэгт учирч болох саадаас зайлсхийх арга зам;</p> <p>(iii) тухайн нисдэг тэргэнд ноцтой доголдол гарсан тохиолдолд авах арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>(iv) тухайн үйл ажиллагааг гадаргуу дээрх хүн, эсхүл өмч хөрөнгөнд аюул учруулахгүйгээр гүйцэтгэх боломжит арга хэмжээ авсан болохыг бататгах зорилгоор Монгол Улсын Стандартын эрх бүхий байгууллагаас гаргасан Эрсдэлийн Удирдлагын Стандартын дагуу боловсруулсан эрсдэлийн үнэлгээ хийх болон эрсдэлийг бууруулах журам;</p> <p>(v) НХУ-ын үйлчилгээтэй хийх шаардлагатай</p>	<p>133.69. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг</p> <p>(a) Хүн ам шигүү суурьшсан газар нутаг, хот, суурин дээгүүр дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга:</p> <p>1/ дараах зүйлийг багтаасан ажлын төлөвлөгөө боловсруулж тухайн ажиллагаанд оролцох бүх байгууллага, хүмүүст танилцуулсан байна:</p> <p>1.1 нислэгийн чиглэл ба өндрийг заасан зураглал;</p> <p>1.2 нислэгийн саадаас зайлсхийх арга зам;</p> <p>1.3 онцгой тохиолдлын үед буулт үйлдэх боломж;</p> <p>1.4 онцгой тохиолдолд ачааг зориудаар салгах болон ачаа санамсаргүй салах үед газарт байгаа хүн болон эд зүйлсэд хохирол учруулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ;</p> <p>1.5 нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний зохицуулалт.</p> <p>2/ энэ зүйлийн 1/-д заасан ажлын төлөвлөгөөг тухайн ажиллагааг</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.3-аар өөрчлөгдсөн</p>

<p>зохицуулалт;</p> <p>(2) энэ зүйлийн (1)-д заасан төлөвлөгөөг тухайн үйл ажиллагааг гүйцэтгэсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаанд хадгалах;</p> <p>(3) холбогдох нутгийн захиргааны эрх бүхий байгууллагад бичгээр урьдчилан мэдэгдэх;</p> <p>(4) нутгийн захиргааны эрх бүхий байгууллагын шаардлагыг мөрдөх;</p> <p>(5) гүйцэтгэх үйл ажиллагааны талаар олон нийтэд үр дүнтэй хэлбэрээр урьдчилан мэдээлэх.</p>	<p>гүйцэтгэсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална,</p> <p>3/ нутгийн захиргааны байгууллагад бичгээр урьдчилан мэдэгдэнэ,</p> <p>4/ явуулах гэж буй ажиллагааныхаа тухай мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.</p>	
<p>133.71. Нисдэг тэрэгний доор хүн өргөх</p> <p>(a) Нисдэг тэрэгний доор хүн өргөх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) тухайн нисдэг тэрэг нь газрын нөлөөгүй агаарт тогтох нислэг (НОГЕ) үйлдэх жингийн 90%-иас хэтэрсэн жинтэй үйл ажиллагаа гүйцэтгэхгүй байх;</p> <p>(2) тухайн хүн тээвэрлэх зай нь, тухайн үйл ажиллагааны зорилгыг биелүүлэхэд шаардлагатай минимум зайд байх;</p> <p>(3) тухайн хүнийг бэхэлсэн татлагат төхөөрөмжийг багийн гишүүн нисдэг тэрэгнээс салгах боломжтой байх ба салгах системийг түүнийг салгахын тулд хоёр тусдаа үйлдэл хийдэг байхаар бүтээсэн байх ёстой;</p> <p>(4) тухайн хүнийг бэхэлсэн татлагат төхөөрөмжийг санамсаргүй салгах боломжгүй хэлбэрээр хийсэн байх;</p> <p>(5) тухайн нисдэг тэрэг нь дараах аюулгүй маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэх:</p> <p>(i) диаметр нь тухайн нисдэг тэрэгний нийт уртаас хоёр дахин их;</p> <p>(ii) тухайн нисдэг тэрэгний хамгийн доор бэхлэсэн хэсгээс доош, босоо тэнхлэгт нэг метрийн дотор аливаа саадгүй;</p> <p>(iii) өргөгч-төхөөрөмжөөр өргөх эсхүл буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөхөд саадгүй талбай.</p> <p>(b) Нисдэг тэрэгний дарга нь нисдэг тэргэнд бэхэлсэн өргөгч-төхөөрөмжөөр хүн өргөх, эсхүл буулгахдаа дараах шаардлагыг бататгана:</p> <p>(1) тухайн буулгах хүнийг суудлын бүсээ тайлахаас өмнө</p>	<p>133.71. Дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх</p> <p>(a) Нисдэг тэрэгний дүүжин хэлбэрийн тээвэрлэлтээр хүн зөөвөрлөх агаарын хөлгийн дарга дараах зүйлийг бататгасан байна:</p> <p>1/ нислэгийг, газрын үйлчлэлийн нөлөөгүй дүүжин нислэг үйлдэх үеийн тооцоот жингийн 80 хувиас илүү хүндтэйгээр гүйцэтгэхгүй байх;</p> <p>2/ хүн зөөвөрлөх зай нь тухайн ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хамгийн богино зай байх;</p> <p>3/ хүн өргөх, буулгах, зөөвөрлөх хэрэгсэл нь хоёр тусдаа үйлдлээр нисдэг тэрэгнээс салгагдах системтэй байх ба нисэх багийн гишүүн салгах боломжтой байх;</p> <p>4/ хүн өргөх, буулгах, зөөвөрлөх хэрэгсэл нь хоёр тусдаа үйлдлээр нисдэг тэрэгнээс салгагдах системтэй байх ба нисэх багийн гишүүн салгах боломжтой байх;</p> <p>5/ хүн өргөж, зөөвөрлөх хэрэгсэл нь болгоомжгүй үйлдлийн улмаас салах боломжгүй байх;</p> <p>6/ нисдэг тэрэгний жолоодлогыг аюулгүй гүйцэтгэхийн тулд:</p> <p>6.1 нислэг үйлдэх орон зайн хэмжээ нь нисдэг тэрэгний уртаас 2 дахин их байх;</p> <p>6.2 нисдэг тэрэгний хамгийн доод цэгээс аливаа саад хүртэл 1 метрээс доошгүй зайг барих;</p> <p>6.3 хүн өргөх, буулгах, зөөвөрлөх орчин нь тухайн үйл ажиллагаанд саад болохооргүй байх.</p> <p>(б) Агаарын хөлгийн дарга нисдэг тэрэгнээс хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглан хүн өргөх, эсхүл буулгахдаа дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ хүн доош буулгах тохиолдолд суудлын даруулга бүсийг</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-80 хувийг 90 хувь болгож өөрчилсөн</p> <p>-Хүчинтэй мөрдөгдөж буй дүрэмд дугаарлалт алдаж, шаардлагыг давхардуулсан</p>

<p>татлагад бэхэлсэн байх;</p> <p>(2) дээш өргөн гаргаж авсан хүнийг татлагаас тайлахын өмнө суудлын бүсийг бэхэлсэн байх;</p> <p>(2) тухайн хүн ухаан алдсан, эсхүл ойлгох чадваргүй байхаас бусад тохиолдолд, нисдэг тэрэгний багийн гишүүн тухайн хүнд үйл ажиллагаатай холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн журмын зааварчилгаа өгсөн байх</p> <p>(с) Нисдэг тэрэгний дарга нь бэртэж гэмтсэн хүнийг нисдэг тэрэгний доор бэхэлсэн даруулга бэхэлгээ, эсхүл дамнуургаар зөөх үед дараах нөхцөлийг бататгана: тухайн этгээдийг тээвэрлэх зай нь дараах ажиллагаанд шаардлагатай минимум зайд байх:</p> <p>(1) тухайн этгээдийг тээвэрлэх зай нь дараах ажиллагаанд шаардлагатай минимум зайд байх:</p> <p>(i) тухайн этгээдийг илүү тохиромжтой тээврийн хэрэгсэлд шилжүүлэх; эсхүл</p> <p>(ii) аюулгүй буулт үйлдэж, татлагаар бэхэлсэн хүнийг нисдэг тэргэн дотор шилжүүлэх.</p> <p>(d) Нисдэг тэрэгний дарга олсоор буулгах үйл ажиллагааг гүйцэтгэхдээ, олсоор буух этгээдийг дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) тухайн гүйцэтгэж байгаа олсоор буулгах үйл ажиллагаатай холбоотой сургалтын курст амжилттай хамрагдсан байх;</p> <p>(2) тухайн үйл ажиллагаатай холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн журмын талаар багийн гишүүнээс зохих зааварчилгаа авсан байх;</p> <p>(3) суудлын бүсээ тайлахаас өмнө олсонд бэхлэгдсэн байх.</p>	<p>тайлахаас өмнө түүнийг холбоосонд бэхэлсэн эсэх;</p> <p>2/ дээш өргөсөн тохиолдолд холбоосыг салгахаас өмнө тухайн хүнийг суудлын даруулга бүсээр бүсэлсэн, эсхүл аюулгүйн оосорт бэхэлсэн эсэх;</p> <p>3/ ухаан алдсан буюу сэтгэх чадвараа алдсанаас бусад хүнд нисэх багийн гишүүд нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын журмыг танилцуулж зааварчлага өгсөн эсэх.</p> <p>(в) Агаарын хөлгийн дарга нь бэртсэн, гэмтсэн хүнийг аюулгүйн бүслүүр, торон дамнуургын тусламжтай дүүжин хэлбэрээр зөөвөрлөхдөө дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ дараах ажиллагаанд шаардагдах зөөвөрлөлтийн зай нь хамгийн богино зай байна гэдгийг:</p> <p>1.1 тухайн гэмтэж бэртсэн хүнийг тээвэрлэхэд илүү тохиромжтой тээврийн хэрэгсэлд шилжүүлэх,</p> <p>1.2 аюулгүй бууж, зөөвөрлөж байгаа хүнээ нисдэг тэргэндээ шилжүүлэх.</p> <p>2/ ухаан алдсан буюу сэтгэх чадвараа алдсанаас бусад хүнд нисэх багийн гишүүд нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын журмыг танилцуулж зааварчлага өгсөн эсэхийг.</p> <p>(г) Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэгнээс зориулалтын олс, оосор ашиглан хүн буулгах ажиллагааг гүйцэтгэх этгээдийн хувьд дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ олс, оосор ашиглан хүн буулгах дадлага сургалтанд хамрагдсан байх;</p> <p>2/ нисэх багийн гишүүдээс олс татуурга ашиглан хүн буулгах үеийн нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын талаар зааварчлага авсан байх;</p> <p>3/ хүн доош буулгахдаа суудлын даруулга бүсийг тайлахаас өмнө түүнийг олс оосорт бэхэлсэн эсэх.</p>	
<p>133.73. Нэмэлт багийн нэмэлт гишүүн</p> <p>(a) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга, нэмэлт багийн гишүүн нь дараах шаардлага хангаж байгааг бататгана:</p> <p>(1) Нисдэг тэрэгний дарга дараах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй үед:</p> <p>(i) татлагаар өргөх, эсхүл буулгах төхөөрөмжийг ажиллуулах; эсхүл</p>	<p>133.73. Багийн нэмэлт гишүүн</p> <p>(a) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга:</p> <p>1/ дараах үйлдлүүдийг өөрийн биеэр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд багийн нэмэлт гишүүнийг авч явна:</p> <p>1. 1 хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглах,</p> <p>1.2 ачааг хянах, ажиглах,</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<ul style="list-style-type: none"> (ii) ачааг хянах; эсхүл (iii) ачааг салгах; эсхүл (iv) зайг ажиглах; эсхүл (v) хүмүүсийг суулгах буулгах. <p>(2) хөөрөлт үйлдэхийн өмнө тухайн үйл ажиллагаа болон гүйцэтгэх тодорхой ажил үүргийн талаар бүрэн зааварчилгаа авсан байх;</p> <p>(3)</p> <p>(4) онцгой нөхцөлийн үед хялбар тайлах боломжтой, гэхдээ санамсаргүй байдлаар тайлагддаггүй даруулгаар бэхлэгдсэн байх;</p> <p>(5) нисгэгчтэй хоёр талын холбоо барих боломжтой системээр хангагдсан байх.</p>	<p>1.3 ачааллыг салгах,</p> <p>1.4 саадыг ажиглах,</p> <p>1.5 хүмүүсийг агаарын хөлгийн бүхээгт оруулах, бүхээгнээс гаргах.</p> <p>2/ багийн нэмэлт гишүүн өөрийн гүйцэтгэх ажиллагаа болон тусгай даалгаврын талаар хөөрөлтийн өмнө бүрэн танилцсан байна;</p> <p>3/ багийн нэмэлт гишүүн аюулгүйн бүсийг бүсэлсэн байх бөгөөд бүс нь онцгой тохиолдлын үед салгахад хялбар, санамсаргүй салахааргүй байна;</p> <p>4/ багийн нэмэлт гишүүн нь нисгэгчтэй хоёр талын харилцаатай байхын тулд холбооны төхөөрөмжөөр хангагдсан байна.</p>	
<p>133.75. Багийн гишүүдийн ур чадвар</p> <p>(a) Багийн бүх гишүүд нь тухайн үйл ажиллагаа, агаарын хөлөг, тоног төхөөрөмжтэй холбоотой хэвийн болон онцгой нөхцөлийн маневрыг гүйцэтгэх чадвар, техникийн мэдлэг болон ур чадвараа харуулах шалгалт өгсөн, эсхүл шалгалтын нислэгийг амжилттай хийлгэсэн байхаас бусад тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь өргөгч-төхөөрөмжөөр өргөх эсхүл буулгах, олсоор буулгах, эсхүл татлагаар хүн зөөх үйл ажиллагаа гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан шалгалт, эсхүл шалгалтын нислэгийг дараах шаардлагын дагуу гүйцэтгэнэ:</p> <p>(1) дараах гэрчилгээ эзэмшигч:</p> <ul style="list-style-type: none"> (i) тухайн эзэмшигчийг шалгалт авах, эсхүл шалгалтын нислэг хийхийг зөвшөөрсөн, ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ; эсхүл (ii) тухайн эзэмшигчийг шалгалт авах, эсхүл нислэгийн үнэлгээг хийхийг зөвшөөрсөн, ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ; <p>(2) шаардлагатай маневрыг гүйцэтгэх багийн гишүүний чадварт зохих ёсоор үнэлгээ өгөх боломжтой агаарын хөлгөөр;</p> <p>(3) нислэг үйлдэхийн өмнөх 24 сарын хугацаанд.</p> <p>(c) Энэ зүйлийн (a)-д заасан шалгалт, эсхүл шалгалтын нислэг нь тухайн үйл ажиллагаанд гарч болох бүх хэвийн, онцгой нөхцөлийн болон дараах шаардлагыг багтаасан байна:</p> <ul style="list-style-type: none"> (1) нислэгт бэлтгэх; (2) багийн удирдлагын менежмент; (3) зорилгот байг тодорхойлох болон нисдэг тэргийг 	<p>133.75. Нисэх багийн гишүүдийн бэлтгэл</p> <p>(a) Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн үйл ажиллагаа, агаарын хөлөг болон тоног төхөөрөмжийн талаарх мэдлэг, нислэгийн хэвийн болон онцгой тохиолдлын үед авах арга хэмжээ, нислэгийн бэлтгэл, ур чадвараа шалгуулаагүй нисэх багийн гишүүнийг энэ дүрэмд заасан үйл ажиллагаанд оролцуулахгүй.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан шалгалтыг:</p> <ul style="list-style-type: none"> 1/ тухайн шалгалтыг гүйцэтгэх эрх олгогдсон, ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллага гүйцэтгэнэ; 2/ нисэх багийн гишүүдийн жолоодлого хийх чадварыг үнэлэх боломжтой агаарын хөлөг дээр гүйцэтгэнэ; 3/ тухайн нислэгийн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор өгсөн байна. <p>(в) Энэ зүйлийн (a)-д заасан шалгалт нь дараах зүйлийг багтаасан нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын үеийн ажиллагааны журмыг хамарна:</p> <ul style="list-style-type: none"> 1/ нислэгийн өмнөх бэлтгэл; 2/ нисэх багийн зохион байгуулалт; 	<p>-“12 сар” гэснийг “24 сар” болгож хугацааг хугатасан.</p>

<p>зөв байрлуулах;</p> <p>(4) холбоо алдагдах;</p> <p>(5) аюул тулгарсан ажилтанд тусламж үзүүлэх журам;</p> <p>(6) нисдэг тэрэгний анхааруулах гэрэл;</p> <p>(7) хөдөлгүүрийн чадал алдагдах;</p> <p>(8) цахилгаан тэжээл татгалзах.</p> <p>(d) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэдэг үйл ажиллагаа эрхлэгч нь бүх шалгалтын болон шалгалтын нислэгийн бүртгэлийг 4-өөс доошгүй жил хадгална.</p> <p>(e) Сургалтын зорилгоор нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа нисдэг тэрэгний дарга хот, сум, эсхүл суурингийн дээгүүр, эсхүл түүний дэргэд тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхгүй байхыг бататгана.</p>	<p>3/ холбоо алдагдах;</p> <p>4/ аюулын үед туслах ажилтны ажиллах журам;</p> <p>5/ нисдэг тэрэгний анхааруулах гэрлэн дохионууд;</p> <p>6/ хөдөлгүүрийн чадал алдагдах;</p> <p>7/ цахилгааны дутагдал.</p> <p>(г) Тээвэрлэгч нь шалгалтын материалыг 2 жил хадгална.</p> <p>(д) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь хүн ам шигүү суурьшсан газар нутаг, хот, суурин дээгүүр дадлагын нислэг үйлдэж болохгүй гэдгийг бататгана.</p>	<p>-шалгалтын материалыг 2 жил хадгалдаг байсныг 4 жил болгон уртасгасан</p>
<p>С Бүлэг - Нөөц</p>	<p>В БҮЛЭГ. НӨӨЦ</p>	
<p>D Бүлэг - Нөөц</p>	<p>Г БҮЛЭГ. НӨӨЦ</p>	
<p>E Бүлэг - Нөөц</p>	<p>Д БҮЛЭГ. НӨӨЦ</p>	
<p>F Бүлэг - Хэрэглэл болон Төхөөрөмж</p>	<p>Е БҮЛЭГ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ</p>	
<p>133.251. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь ИНД-91-ийн шаардлага дээр нэмж, дүүжин ачаа тээвэрлэж байгаа нисдэг тэрэгний шаардлагатай хэрэглэл төхөөрөмжийг тогтооно.</p>	<p>133.251. Нөөц.</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>133.253. Ерөнхий зүйл (a) Энэ Бүлэгт шаардсан хэрэглэл болон төхөөрөмж дараах шаардлага хангасан байхаас бусад тохиолдолд нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч, тухайн нислэгийг эхлүүлдэггүй болохыг бататгана:</p> <p>(1) дараах баримт бичигт заасан үзүүлэлт болон НТЧ-ын загварын стандартыг хангасан байх:</p> <p>(i) энэ Бүлэг; эсхүл</p> <p>(ii) тухайн үйл ажиллагааны хувьд, Даргын баталсан өөр орлох үзүүлэлт болон стандарт;</p> <p>(2) үйл ажиллагааны болон НТЧ-ын шаардлагыг багтаасан холбогдох шаардлагын дагуу суурилуулсан байх;</p> <p>(3) ажиллагаатай нөхцөлд байх бөгөөд гүйцэтгэх үйл ажиллагааны төрөлд шаардлагатай тоотой байх.</p>	<p>133.253. Ерөнхий зүйл. (a) Нисдэг тэрэгний дүүжин тээвэрлэлтэд ашиглах тоног төхөөрөмж, хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ энэ бүлэгт зааснаас гадна тухайн үйл ажиллагаанд зориулан ИНЕГ-аас зөвшөөрсөн нэмэлт тодорхойлолт, эсхүл нэмэлт стандартуудад тусгагдсан НТЧ-ын хийцийн стандарт, тодорхойлолтын шаардлагад нийцсэн байх;</p> <p>2/ НТЧ, нислэгийн үйл ажиллагааны шаардлага болон холбогдох бусад шаардлагын дагуу суурилагдсан байх;</p> <p>3/ хэвийн ажиллагаатай байх ба тухайн төрлийн үйл ажиллагаанд</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>

	шаардлагатай тоо хэмжээтэй байх.	
<p>133.255. Дүүжин ачааны төхөөрөмж Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн нисдэг тэргийг дараах хэрэглэлээр тоногдсон болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) тухайн нисдэг тэргэнд ашиглахыг нисдэг тэргэний үйлдвэрлэгч зөвшөөрсөн, эсхүл ИНД-21-ийн С Бүлгийн хүрээнд загварын өөрчлөлтийн дагуу зөвшөөрсөн ба суурилуулсан ачааны өргөх дэгээ, эсхүл түүнтэй төстэй төхөөрөмж;</p> <p>(2) дараах дүүжин <u>ачааны</u> төхөөрөмж:</p> <p>(i) өөрөө эвдрэх, эсхүл нисдэг тэргийг гэмтээхээс <u>сэргийлсэн</u> стандартын бөгөөд тохирсон;</p> <p>(ii) тухайн төхөөрөмжийг ашиглан хүн <u>зөөх тохиолдолд даацын</u> жингээс 3.75 дахин их ачаалал даах чадвартай.</p>	<p>133.255. Дүүжин <u>тээвэрлэлтэд ашиглах тоног төхөөрөмж</u></p> <p>(а) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх нисдэг тэрэг нь үйлдвэрлэгчээс, нисдэг тэргэнд ашиглахыг зөвшөөрсөн <u>ачааны дэгээ</u>, хэрэгслээр тоноглогдсон байна.</p> <p>(б) Дүүжин <u>тээвэрлэлтэд</u> ашиглах төхөөрөмж нь:</p> <p>1/ нисдэг тэргийг гэмтээхээс болон өөрөө <u>хугарч</u> эвдрэхээс <u>сэргийлэгдсэн</u>, зохих стандартын дагуу хийгдсэн;</p> <p>2/ хүн зөөвөрлөх тохиолдолд тухайн жингээс 3.75 дахин хүнд ачааллыг даах чадвартай.</p>	<p>-Amend.3-аар нэмэгдсэн</p>

<p>133.257. Түргэн салгах төхөөрөмж</p> <p>(a) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн нисдэг тэргийг дараах төхөөрөмжөөр тоноглон болохыг бататгана:</p> <p>(1) түргэн салгах цахилгаан төхөөрөмж;</p> <p>(2) механик, эсхүл бие даасан түргэн салгах цахилгаан төхөөрөмж.</p> <p>(b) Үйл ажиллагаа эрхлэгч, энэ зүйлийн (a)-д шаардсан түргэн салгах төхөөрөмж нь тухайн нисдэг тэргийн максимум дүүжин ачааг багтаасан, бүх дүүжинт ачааны даацад тохирч байгааг бататгана.</p> <p>(c) Үйл ажиллагаа эрхлэгч, тухайн түргэн салгах систем нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) дараах үндсэн удирдлагатай байх:</p> <p>(i) аль нэг нисгэгчийн үндсэн нислэгийн удирдлага дээр суурилуулсан;</p> <p>(ii) онцгой нөхцөлийн үед нисгэгч түүнийг ажиллуулахад, тухайн нисдэг тэргийг удирдах нисгэгчийн чадварыг хязгаарлахгүй байхаар зохион бүтээгдэж байрлуулсан.</p> <p>(2) багийн гишүүн хялбар авч хэрэглэх боломжтой хоёрдогч удирдлагатай байх.</p>	<p>133.257. Түргэн салгах хэрэгсэл</p> <p>(a) Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь дүүжин тээвэрлэлтэд ашиглах хэрэгслийн хувьд дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ түргэн салгах цахилгаан төхөөрөмжөөр тоноглогдсон;</p> <p>2/ механик ажиллагаатай, эсхүл түргэн салгах бие даасан цахилгаан төхөөрөмжөөр тоноглогдсон.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д дурьдсан түргэн салгах хэрэгслийн ажиллагаа нь дүүжин тээвэрлэлтийн хамгийн их ачаалалтай байх нөхцөлд хэвийн гэдгийг Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь баталгаажуулна.</p> <p>(в) Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь түргэн салгах тоноглолын хувьд дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ анхдагч удирдлагатай байх ба тэр нь:</p> <p>1.1 аль нэг нисгэгчийн жолоон дээр суурилагдсан,</p> <p>1.2 онцгой тохиолдлын үед нисгэгч нислэгийн жолоодлогыг гүйцэтгэхэд саад болохооргүй, ажиллуулахад тохиромжтой байрлагдсан, хийгдсэн.</p> <p>2/ нисэх багийн гишүүд шууд хүрч ажиллуулах боломжтой хоёрдогч удирдлагатай байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>“нисгэгчийн жолоо” гэснийг “нислэгийн удирдлага” болгож өөрчилсөн</p>
<p>Г Бүлэг - Техник үйлчилгээ</p>	<p>Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ</p>	
<p>133.301. Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дүүжиначаа тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглаж байгаа Монгол Улсын бүртгэлтэй нисдэг тэргийн техник үйлчилгээний шаардлагыг тогтооно.</p>	<p>133.301. Нөөц</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>133.303. Техник үйлчилгээний шаардлага Үйл ажиллагаа эрхлэгч нь 133.255(1)-д шаардсан ачааны өргөх дэгээ, эсхүл түүнтэй төстэй бусад төхөөрөмжийг багтаасан, тухайн нисдэг тэргийн техник үйлчилгээг ИНД-91 болон энэ Дүрмийн дагуу хийдэг болохыг бататгана.</p>	<p>133.303. Техник үйлчилгээнд тавих шаардлага (a) Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч нь нисдэг тэрэг болон энэ дүрмийн 133.255-ын 1/-д заагдсан ачааны дэгээ, хэрэгслийн хувьд ИНД-91 болон энэ дүрмийн дагуу техник үйлчилгээний шаардлагуудыг хангана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>133.305. Техник үйлчилгээг гэрчилгээжүүлэх этгээд Үйл ажиллагаа эрхлэгч ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь зохих ёсоор сургалтад хамрагдаж,</p>	<p>133.305. Техник үйлчилгээний ажилтан (a) Тоног төхөөрөмжийг техник үйлчилгээнээс гаргах ажилтан нь тухайн ажлын чиглэлээр мэргэшсэн, сургалт дадлагад бүрэн</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тухайн гэрчилгээжүүлэлтийг хийхээр мэргэшсэн болохыг бататгана.</p>	<p>хамрагдсан, эрх бүхий этгээд гэдгийг агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч бататгана.</p>	
<p>133.307. Дүүжин ачааны төхөөрөмж</p> <p>(a) Үйл ажиллагаа эрхлэгч дүүжин ачааны төхөөрөмж нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:</p> <p>(1) <u>хэвийн бус байдлын шинж тэмдгийг шалгах нүдэн үзлэгийг өмнөх ашиглалтын</u> 50 цаг тутамд хийсэн байх;</p> <p>(2) өмнөх 12 сар, эсхүл ашиглалтын 500 цагийн аль түрүүлж болох хугацаанд, түүний <u>тооцоот</u> ачааллаас 1.25 дахин <u>их ачаалал</u> өгч шалгасан байх.</p> <p>(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (a)-д заасан, дүүжин ачааны төхөөрөмжийн үйлчилгээг <u>орлох засвар үйлчилгээг дараах хуваарийн дагуу</u> хийж болно:</p> <p>(1) заавал мөрдөх солих хугацаа, үзлэг <u>шалгалтын үечлэл</u> болон үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний заавар, эсхүл НТЧ-ын байнгын хадгалалтын зааварчилгаанд заасан холбогдох журам; эсхүл</p> <p>(2) ИНД-91, эсхүл ИНД-119-ийн дагуу батласан техник үйлчилгээний хөтөлбөр.</p>	<p>133.307. Гадна хэрэгсэл</p> <p>(a) <u>Агаарын тээврийн</u> үйл ажиллагаа эрхлэгч нь гадна хэрэгслийг:</p> <p>1/ ашиглалтын 50 цаг тутамд үзэж элэгдэл, <u>эвдрэлийн шинж тэмдэг илэрч буй эсэхийг шалгана</u>;</p> <p>2/ ашиглалтын 500 цаг буюу 12 сарын аль эхэлж болсон хугацаанд түүний <u>зөвшөөрөгдсөн</u> ачааллаас 1.25 дахин их ачааг <u>туршилтын байдлаар</u> ачаалж шалгана.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д зааснаас гадна, <u>агаарын тээврийн</u> үйл ажиллагаа эрхлэгч нь <u>гадна хэрэгслийн</u> хувьд дараах үйлчилгээг хийж болно:</p> <p>1/ НТЧ-ын хадгалалтын зааварчлага, эсхүл үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний зааварт тусгагдсан холбогдох журам, зайлшгүй солих хугацаа болон үзлэг <u>шалгалтын үечлэл</u>, эсхүл</p> <p>2/ ИНД-91, эсхүл ИНД-119-ийн дагуу батлагдсан Техник үйлчилгээний хөтөлбөр.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>